

**2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 07 дугаар сарын 17-ны “Баасан” гарагийн 12:00 цагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ДҮҮРГИЙН ЗДО-оос ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх улсын байцаагчдын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллах.	ЗДТГ, МЭТ
2	“Манай хороо - Миний гудамж” аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодыг идэвхтэй оролцуулж, олон нийтэд сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулах.	ТХҮХ, ААНБ-ууд, Хороод
3	“Монгол Улсын эдийн засгийн форум 2023” арга хэмжээнд оролцох хүрээнд бэлтгэл ажлыг ханган идэвхтэй оролцох	ЗДТГ
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХАЖЛЫН ХҮРЭЭНД		
4	“Дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженер хангамжийн засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэн, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, Дэд бүтцийн байгууллагууд
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
5	Гамшиг ослын болон гол, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, авто замын барилга, байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үерийн далан сувгийн засвар шинэчлэл, цэвэрлэгээний ажлуудаа эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, ОБХ, Дэд бүтцийн байгууллагууд
6	Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах.	ТХҮХ
7	Дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлуудыг дүүргүүдийн өмчид бүртгэж, эзэмшигч, ашиглагчийг тодорхой болгож, засвар, үйлчилгээ арчлалтыг хариуцан ажилладаг бодлого, чиглэл баримталж ажиллах.	ТХҮХ
8	Гэрэлтүүлэг болон хяналтын камеруудын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах.	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
БАЯР НААДМЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
9	Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, холбогдох байгууламжуудын засвар үйлчилгээ, стандартыг дагуу тохижилтын ажлыг чанартай гүйцэтгэж, дуусгах.	ТХҮХ,
10	Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ус, цахилгаан хангамжаар байгууллага, иргэдийг тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлэх.	ТХҮХ, Дэд бүтцийн байгууллагууд
11	Хог хаягдалгүй байлгахад анхаарч, цэвэрлэгээний ажлыг сайтар зохион байгуулах	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ-ууд

12	Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах урьдчилан сэргийлж ажиллах.	ТХҮХ, МЭТ
13	Баяр наадмын үеэр үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн хөдөлгөөнт тоглоомуудын хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах.	ТХҮХ, ОБХ, ГБХЗХХ
14	Баярын өдрүүдэд байгууллагууд хариуцлагатай эргүүл жижүүр ажиллуулах.	ЗДТГ, ААНБ-ууд
15	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулж ажиллах	Цагдаагийн хэлтэс